

**ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-23
1.Дэд хорооны тогтоолын төсөл /Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчиж буй болон тус улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн зарим эрхийн хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай/	3-23

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны
06 дугаар сарын 25-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 9 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 14 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Баасанжаргал.

Нэг.Дэд хорооны тогтоолын төсөл /Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчиж буй болон тус улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн зарим эрхийн хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, мөн Комиссын Тамгын газрын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, референт Э.Одбаяр, Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг, Хүний эрхийн дэд хорооны ажилтан Ч.Түвшинбилэг нар байлцав.

Дэд хорооны дарга С.Эрдэнэболд тогтоолын төслийг Дэд хорооны гишүүдэд тараасан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Бат-Эрдэнэ, М.Нарантуяа-Нара, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга Б.Болд, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Дэд хорооны дарга С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Бат-Эрдэнэ, М.Нарантуяа-Нара, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Дэд хорооны дарга С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Дэд хорооны ирцээс гарч, санал хураалтад оролцохгүй байх тухайгаа мэдэгдэв. /11:21/

С.Эрдэнэболд: “Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчиж буй болон тус улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн зарим эрхийн хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Дэд хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин нарын саналыг тусган батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 2

Бүгд: 7

71.4 хувийн саналаар Дэд хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 10 минут үргэлжилж, ирвэл зохих 9 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД

ХОРООНЫ ДАРГА

С.ЭРДЭНЭБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
10 цаг 14 минут.

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Эрдэнэболд: Сайн байцгаана уу? Улаанбаатарт 10 цаг 14 минут.

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан эхлэх гэж байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалд “Гадаад улс дахь Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Хүний эрхийн дэд хорооны тогтоолын төслийг авч хэлэлцэх гэж байгаа.

Хэлэлцэх асуудлыг батлахаас өмнө товчхон мэдээлэл өгөхөд Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Солонгос Улсын хил дээрээс буцаагдсан хэдэн зуун тохиолдол гарсан. Энэ асуудлаар бас иргэд Хүний эрхийн Үндэсний Комисст хандаж, мөн Хүний эрхийн дэд хороо энэ талаар мэдээллүүд авсан.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ бас албан хүсэлт манай дэд хороонд ирүүлж, бид 5 дугаар сарын 14-ний өдрөөс 5 дугаар сарын 31-ний хооронд тус хохирсон хүмүүсийн төлөөллийг, ер нь нийт хохирсон хүмүүс Хүний эрхийн Үндэсний Комисс дээр яг тодорхой албан тушаалтан, өргөдөл, гомдол хүлээж авах албан тушаалтан өрөө байр гаргаад нийтдээ 14 хоногийн хугацаанд хохирогчдын төлөөллийг хүлээж авч уулзсан. Ер нь олон зуун хүн учраас бас 2 долоо хоногийн хугацаа ингэж зарцуулсан.

Ингээд 6 дугаар сарын 18-ны өдөр хохирогчдын төлөөлөл болон бодлого боловсруулах шийдвэр гаргах байгууллагуудын төлөөлөл, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, мөн Хүний эрхийн Үндэсний Комисс болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг хүлээж авч Хүний эрхийн дэд хороон дээр бас уулзсан. Эндээ бол санаачлагч буюу хүсэлт гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ гишүүн бас оролцсон байгаа.

Энэний дагуу бас дэд хорооны тогтоол гаргах санаачилга гаргаад тогтоолын төслийг бас та бүхэнд танилцуулаад явж байгаа юм. Энэ товч мэдээлэл өгөхөд ийм байна.

Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Тэгэхээр асуудалдаа оръё.

“Гадаад улс дахь Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Хүний эрхийн дэд хорооны тогтоолтой холбогдуулаад бас зарим байгууллагуудыг

урьсан байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссоос Энхболд тэргүүтэй хүмүүс байна. Ууганбаатар дарга.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн референт Э.Одбаяр нарын албан тушаалтнуудыг өнөөдрийн хуралд оролцуулж байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Гишүүнээр тасална. Та Сандаг-Очир гишүүн өөр? Өнөөдөр бас тус тогтоолын төслийн талаарх санаачилга гаргасан бас Бат-Эрдэнэ гишүүн байна. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Гадаадад байгаа Монгол Улсынхаа иргэдийн талаар, тэдний хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр Хүний эрхийн дэд хороо маань бас асуудлыг авч хэлэлцэж, тодорхой асуудлаар тогтоол гаргаж, Засгийн газарт холбогдох байгууллагуудад чиглэл болгож хугацаатай ийм тогтоол боловсруулж орж ирж байгааг дэмжиж байна.

Гэхдээ манай тогтоолын гарчиг бол Гадаад улс дахь Монгол Улсын иргэний гэж яваа. Гэтэл тогтоолоо үзэхээр ерөөсөө 1, 2, 3, 4 гээд бүгд дандаа Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийн чиглэлээр ерөөсөө явчихсан байна. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр гарчгаа ерөөсөө шууд “Бүгд Найрамдах Солонгос Улсад гэх юм уу гээд иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэсэн тогтоол болгох юм уу, эсвэл гарчиг маань ийм байгаа юм чинь доторх тогтоолын заалтууд маань бүгд бусад улс оронд адилхан байж, бас ялгаатай байх ёстой. Ер нь зорчиж байгаа иргэдийн бараг 70, 80 хувь нь Солонгос улсад ажиллаж, амьдарч байгаа байх, асуудлууд тэнд үүсээд байгаа байх.

Тэгэхээр энэ гарчиг болоод тогтоолын доторх агуулга 2 маань бас зөрчилдөөд байна уу гэсэн. Энийг юу гэж үзсэн бэ гэдгийг нэгд асууя.

Хоёрт, тогтоолын 3 дахь заалт дээр энэ Солонгос Улсад зорчих Монгол иргэд болон тэдний асран хамгаалагчийг 30 хүртэл хоногийн хугацаанд визийн шаардлагаас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх. Энэ ер нь хэр бололцоо, боломжтой асуудал вэ асран хамгаалагчийг? Асран хамгаалагч нь байтугай бид нар өөрсдөө өвдсөн зовсон гэдэг юм уу, ажиллах гэж байгаа улсууд өөрсдөө гарч чадахгүй байхад тэдний асран хамгаалагчийг хүртэл 30 хоногийн хугацаанд визийн шаардлагаас чөлөөлөх асуудал нь хэр бололцоотой байх юм бэ? Энэ ер нь судалж үзсэн үү? Боломж байгаа юу? Боломж байгаа бол яагаад энийг хийхгүй байгаа юм бэ? Энийг манай Солонгос Улс дахь Элчин сайд, Элчин сайдын яам энэ талаар ер нь урьд өмнө асуудлыг авч хэлэлцэж байсан асуудал байгаа юм уу? Хэлэлцэж байсан яагаад шийдэгдэхгүй байгаа юм? Энийг тодруулж өгөөч? Ийм 2 асуулт байна.

С.Эрдэнэболд: Сандаг-Очир гишүүний нэгдүгээр асуултад Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх Золжаргал, хоёр дугаар асуултад Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд нар хариулна.

Г.Золжаргал: Өглөөний мэнд, эрхэм гишүүдийн өглөөний мэндийг эрье. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тогтоолын төслийн нэр маань яагаад “Гадаад улс дахь Монгол Улсын иргэний эрх эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэж гарч байгаа вэ гэхээр энэ дээр тогтоолын төслийн 2 болон 3, мөн 4 дүгээр эдгээр асуудлууд нь бол зөвхөн Солонгос Улсад зорчиж байгаа болон тэнд амьдарч байгаа иргэдийн талаар биш, нийт хилийн чанад дахь Монгол иргэдийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар тусгасан байгаа учраас нэрээ ингэж нийтлэг байдлаар нэрлэсэн байгаа.

С.Эрдэнэболд: Болд дарга хоёрдугаар асуултад нь хариулахдаа яг эртээр бас Мөнхтүшиг дарга эд нар ярьсан шүү дээ энэ чинь бас 2 улсын хоорондын дипломат харилцаатай холбоотой асуудал гээд та энэ талаар нь бас давхар хариулчих.

2 дугаар микрофон.

Б.Болд: Сайн байцгаана уу та бүхэнд энэ өдрийн өглөөний мэндийг хүргэе. Би Консулын газрын захирал Болд байна. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Гадаад харилцааны яамны зүгээс Солонгосын талд харилцан адил байх зарчмын хүрээнд эргэж зорчих нөхцөлийг хөнгөвчлөх асуудлыг сүүлийн 4, 5 жилийн турш тогтмол тавьж ирсэн. Та бүхэн мэдэж байгаа бид нар Солонгосын иргэдийг ноднингос эхлүүлээд энэ оныг дуустал аялал жуулчлалын зорилгоор ирэх иргэдийг визгүй зорчуулах шийдвэрийг гаргасан. Тэгэхээр харилцан адил байх зөрчлийн хүрээнд манай иргэдийн зорчих нөхцөлд бас хөнгөлөлт үзүүлээч.

Ер нь адилхан визгүй зорчдог болъё гэдэг асуудлыг бид нар тогтмол тавьж ирсэн. Ерөнхий сайд, Гадаад сайдын айлчлалын үеэр ч гэсэн энэ асуудлуудыг бүхий л түвшинд тавьж ирсэн. Харамсалтай нь Солонгосын тал яг энэ асуудлаар одоог хүртэл тодорхой шийдвэр гаргаагүй байгаа. Ер нь уулзаад албаны уулзалт хийгээд явж байхад танай иргэдийг зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр тодорхой шийдвэр гаргахад гол хүндрэл үзүүлж байгаа зүйл нь танай хууль бусаар байгаа иргэдийн тоо байгаа юм. 55 мянга орчим иргэн байгаагаас 18 мянга орчим нь буюу 34, 5 хувь нь хууль бусаар байгаа. Энэ нь Солонгосын талаас тодорхой шийдвэр гаргахад гол бэрхшээлийг үгүйсгэж байна гэсэн ийм тайлбарыг тогтмол тавьж ирсэн.

Гэхдээ бид нар энэ тайлбар дээр тайлбарыг хүлээж аваад зогсохгүй үргэлжлүүлэн ажилласаар байх болно. Эхний ээлжид бүх төрлийн зорилгоор зорчиж байгаа иргэдийг визгүй зорчуулах шийдвэр гаргадаггүй юм гэхэд ядаж эхний ээлжид эмчилгээний зорилгоор зорчиж байгаа иргэдийг визгүй зорчих л шийдвэр гаргадаг ч юм уу, тодорхой нөхцөлийг бас тавиад энэ Солонгосын тал дээр үргэлжлүүлж ажиллаж байгаа.

С.Эрдэнэболд: Болд дарга тэр гарчигтай холбоотой яг гадаад улсын гэж нийтлэгээр нь хэлэх нь зохистой юу? Яг энд тогтоол дээр Бүгд Найрамдах

Солонгос Улс гэж улсын нэр зааж явах нь зохимжтой юу гэдэг талаар Сандаг-Очир гишүүн асуусан. Энэ дээр та бас Гадаад харилцааны яамыг төлөөлж байгаагийн хувьд байр сууриа хэлэхгүй юу.

Б.Болд: Гадаад яамны байр суурь бидний зүгээс хамгийн хүндрэлтэй улс нь иргэд зорчих нөхцөлтэй холбоотой хамгийн хүндрэл үүсэж байгаа улс бол Бүгд Найрамдах Солонгос Улс байгаа. Бусад улстай иргэд зорчих нөхцөл ер нь харьцангуй гайгүй. Виз олголт ч гэсэн ер нь асуудал багатай байгаа. Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр бүх улсыг биш Бүгд Найрамдах Солонгос Улс гэж тодорхой зааж өгсөн нь дээр болов уу гэж бодож байна.

С.Эрдэнэболд: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний нэрийг асуулт асуух дээр нэм нэмнэ үү.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Монгол Улсын парламент дахь Хууль зүйн байнгын хорооны дэргэдэх Хүний эрхийн дэд хорооны нийт гишүүддээ бас талархал илэрхийлье. Монгол Солонгосын найрамдлын парламентын бүлгийн хувиас ирж байгаа санал, хүсэлт, гомдлуудыг харгалзаж үзээд бас энэхүү хүсэлтийг тавьсан. Хүний эрх гэдэг бол бид нар хамгийн их дээдэлж байх ёстой зүйл Үндсэн хуулиар хамгаалагдсан.

Хүний эрхийн Үндэсний Комисс маань харин энэ дээр жоохон цалгардуу хандаж байгаа явдалд маш харамсалтай байгаа. Миний хувьд өнгөрсөн долоо хоногт Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Комиссынхон ирээд ажиллаад явсан гэсэн ийм мэдээлэлтэй байгаа. Үнэн, худлааг нь сайн мэдэхгүй байна албан бус мэдээлэл учраас.

Тэгэхээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс маань энэ дээр та бүхэн уулзалт хийсэн үү? Хийсэн бол ямар үр дүн гаргахаар, ямар хэлцлийн түвшинд асуудлуудыг авч хэлэлцэж ярилцсан бэ гэдгийг би нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт бид нар зарчимтай байх ёстой. Гадаад харилцааны яам өөрсдөө хариулж л байна. Би бас өглөө асуусан. Дэд хорооны тогтоол дотор Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих Монгол иргэдэд тэдний асран хамгаалагчийг 30 хоног хүртэл, 30 хүртэл хоногийн хугацаанд визийн шаардлагаас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх гэдэг заалт орох нь өөрөө хэр зохимжтой вэ гэдгийг би гол нь асуух гээд байгаа юм. Энэ өөрөө бид нар нөгөө хүний эрхтэй холбоотой асуудлууд хөндөөд явж байгаа.

Гэтэл тэн дотор визний асуудал ороод ирж байгаа нь зохимжийн хувьд, хэрэв хууль давсан тогтоол байж болохгүй Дэд хороо, Байнгын хорооны, тогтоомж бас байж болохгүй. Монгол Бүгд Найрамдах Солонгос Улсын бас хуулиар зохицуулагддаг харилцаа гэж ойлгож байгаа. Энийг та бүхэн маань судалж энэ заалтыг оруулсан уу гэдэг ийм 2 асуултыг би асуух гэж байгаа юм. Баярлалаа.

С.Эрдэнэболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх Золжаргал хариулна.

Г.Золжаргал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тогтоолын төсөл дээр, тогтоолын төслийн 1.3 дахь заалтад заасан асуудлын хүрээнд бол энэ асуудлаар 2 орны Засгийн газрын хооронд Монгол Улсын Засгийн газрын зүгээс

албан ёсны ийм хүсэлт, санал тавьсан байгаа. Мөн сая энэ талаар Болд дарга бас сая хэллээ. Тийм учраас энэ асуудлыг бас үргэлжлүүлэн судалж, холбогдох саналыг хүргүүлж, тэдний талаар шийдвэрлүүлэх энэ арга замыг эрэлхийлэх талаар энэ тогтоолын төсөл дээр тусгасан байгаа.

С.Эрдэнэболд: Би энэ дээр бас нэмэлт хариу өгөхөд ер нь бол асуудал Солонгосын хил дээрээс буцаагдсан хэдэн зуун тохиолдол гарсан. Хүний эрхийн Үндэсний Комисс дээр бас судлаад үзэхээр ер нь 5 төрлийн хүний эрхийн зөрчил гарсан байна гэдэг ийм дүгнэлтийг Хүний эрхийн Үндэсний Комиссоос манай Ууганбаатар дарга бас өмнөх хуралдаан дээр танилцуулсан байгаа.

Энэ асуулт, хариултын дараагаар ер нь бас нэмэлт мэдээлэл өгөх үүднээс Хүний эрхийн Үндэсний Комиссоос товч мэдээлэл бас өгье. Тэрнээс өмнө энэ тогтоолыг яагаад ер нь зөвхөн Солонгос гэхгүй нийтлэгээр нь гадаад улсад гэж оруулаад байгаа юм бэ гэхээр өмнөх удаа хурал дээр бас Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг болон энд хохирогчдын төлөөллийн хооронд бас тодорхой ийм санал солилцох үед ер нь энэ хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн нийтлэг асуудлуудын тухай бас яригдсан. Тэгэхээр зөвхөн 1 улсад зориулчихаас гадна ер нь бас түгээмлээр нь хийчих юм бол өөр өөр улсууд дээр ч гэсэн энэ төрлийн асуудал давтагдах магадлалтай гэж харагдаж байгаа.

Энэ тогтоолын төслийн 5 дээр хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн зорчих, хууль ёсны, оршин суух, хөдөлмөр эрхлэлт, ялгаварлан гадуурхлын асуудлаар гарч байгаа хүний эрхийн зөрчлийн гомдол, мэдээлэл болон тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн нэгдсэн цахим сан байгуулж ажиллах гэж байгаа юм. Энэ бол зөвхөн Солонгос улс биш бусад бүх улсад шаардлагатай байгаад байгаа юм. Америкийн Нэгдсэн Улс, Турк ер нь бол 252 мянган Монгол хүн хилийн чанадад байна. Тэгэхэд 50 орчим мянган хүнд нь зориулаад буюу тавны нэгд нь зориулаад хийчихлээр цаана нь үлдэж байгаа 80 хувь нь яах вэ гэдэг асуулт байгаа юм. Ер нь бол мэдээж аль болохоор эрхийн зөрчил гарахгүй байх л хүснэ шүү дээ. Гэхдээ хэрвээ тэр тохиолдолд ... хэрвээ тэгсэн тохиолдолд яах вэ гэдэг зүйл байгаа. Тэгэхээр нэгэнт л Их Хурлын Хүний эрхийн дэд хороо тогтоол гаргах гэж байгаа бол багтаамжийг нь бол илүү өргөн хүрээтэй байх нь цаашид гарч болзошгүй хүний эрхийн зөрчлөөс хамгаалах юм байна гэдэг нэг ийм үндэслэл.

Хоёрдугаарт, төслийн 6 дээр байгаа Дипломат төлөөлөгчийн газар Консулын албаны хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдэд хүний эрх, виз, хөдөлмөр эрхлэлт, оршин суух нөхцөлд тухайн улс орны хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж, гарын авлага, шаардлагатай мэдээллийг тогтмол түгээх зэрэг арга хэмжээ авч ажиллах гэж байгаа.

Мөн 7 дээр нь гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо, тэдний эрх, хууль, ёсны, ашиг сонирхол, нийгмийн хамгаалал, төрийн үйлчилгээний хүртээмжийг харгалзан Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын бүтэц, хүний нөөц, зардал, орон тоог оновчтой зохион байгуулах шинэчлэх талаар судалгаа хийж шүү. Шууд шийдвэр гаргах тухай яриагүй. Шийдвэрийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах гэсэн ийм зүйл байгаа.

Энэ дээр тодорхой жишээлбэл хэлэхэд Дипломат төлөөлөгчийн газрынх нь орон тоо хүрч ядаж байхад хажууд нь бусад төрийн Монгол Улсын Засгийн газрын зарим яамдын салбар нь 20 гаран хүний бүтэцтэй цалин аваад суугаад байдаг бүтээмж байхгүй гэсэн шүүмж байгаад байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр нэгэнт л хилийн чанадад цалин аваад сууж байгаа тийм албан тушаалтан байгаа бол тэрийг илүү зохистойгоор тэнд байгаа монгол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, эрхийг нь хамгаалахад чиглэсэн тэр механизмд функцтэй болгох тухай асуудал бас өнгөрсөн хурлуудаар яригдаад байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ утгаараа бол энэ чинь зөвхөн Бүгд Найрамдах Солонгос Улс төдийгүй бусад улсууд ч гэсэн ийм асуудал гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь бол гадаад харилцааны энийг хашилтад хэлье Консул ч юм уу, Элчин сайдын яам шагналын ч юм уу, хуучин улс төрчдийн тэтгэвэртээ гардаг газар ч гэдэг юм уу, тэдний хамаарал бүхий хүмүүсийн тийм шагналын мест биш яг тэнд байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалдаг тэр бүтэцтэй байх талаас нь бас энэ хүний эрх талаасаа бид нар энэ дээр бас шалгуур тогтоож гаргах нь зүйтэй гэж гарах нь зүйтэй гэж үзээд байгаа юм л даа. Энэ утгаар даа бол бид нар энэ зөвхөн Бүгд Найрамдах Солонгос Улс гэхээс илүүтэйгээр гадаад улс дахь гэж оруулсан байгаа юм. Үндэслэл хоёр нь.

Гуравдугаарт бас бид нар энэ Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улс суух Элчин сайдын яаманд хандсан, Хүний эрхийн дэд хорооноос Хууль зүйн байнгын хорооноос хандсан. Мэдээж энэ дээр бол бид нар парламент учраас бас хандсан. Уулзалт бол ямар нэгэн байдлаар хийгдээгүй байгаа. Харин шулуухан хэлэхэд энэ Бүгд Найрамдах Солонгос Улс гээд нэр заагаад хэлчихлээр энэ нь эргээд дипломат харилцаанд бас тийм таатай уур амьсгал биш магад байх магадлалтай гэдэг болгоомжлол байгаа. Энэ 3 шалтгааны үүднээс ийм тогтоолын төсөл дээр ингэж оруулсан гэдгийг бас би нэмэлтээр Сандаг-Очир гишүүнд хэлж байгаа юм. Тайлбарлаж байгаа юм.

Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн. Гишүүдийн асуулт дууссаны дараагаар Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлэл өгөөд явчихъя.

Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн. Уучлаарай тийм байна энэ Бат-Эрдэнэ гишүүн асуулт асуусан юм байна. Тэр асуултад нь хариулна.

Б.Энхболд: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2025 оны 6 сарын 19, 20-ны өдрүүдэд Ахмадад ээлтэй нийгмийг бүтээх нь Ази-Номхон далайн бүсийн форумыг зохион байгуулсан. Энэ форумыг зохион байгуулалтын үеэр бид бүхэн тусгайлан Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг урих ийм идэвх санаачилгатай нэлээн арга хэмжээ аваад, үүний үр дүнд Хүний эрх Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга 4 хүний бүрэлдэхүүнтэй энэ форумд ирж оролцсон.

Энэ форумын үеэр бол Ази-Номхон далайн бүсийн хүний эрхийн байгууллагуудыг даргалдаг Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын бол байр суурь бас их тодорхой сонсох үүднээс энийг урьсан. Урилгыг хүлээж авч ирсэн. 2 дахь өдөр нь бол яг энэ Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал. 2 улсын хүний эрхийн нөхцөл байдлыг үнэлэх харилцан мэдээлэл солилцох зорилгоор санамж бичгийг байгуулсан байгаа.

Энэ санамж бичгийн хүрээнд бол өнөөдрийн дурдаад байгаа асуудлууд Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Монголчуудын эрхийн асуудлын талаар бол тусгайлан төлөвлөгөө гаргаж ажиллахаар урьдчилсан байдлаар тохирсон. Ирэх долоо хоногийн эхээр бол бид нар цахим уулзалтуудыг хийж, хамтын ажиллагааны асуудлуудаа нарийвчлаад, энэ тогтоолд тусгасан ажлын дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын бүрэн эрхийнх нь хүрээнд тодорхой тэр хүний эрх чөлөөг хязгаарлаж байгаа, гадаад улсын иргэдийн эрх эрх чөлөөг зөрчиж байгаа энэ асуудлыг НҮБ-ын холбогдох дүрэм, журам стандартад нийцүүлэн хяналт шалгалт хийж, мэдээлэл солилцохоор бол тогтсон байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бас тодорхой асуудлууд ахиц дэвшил гарна гэж ингэж найдаж байгаа.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу өдрийн мэнд хүргэе. Энэ Солонгосын асуудлаас гадна бусад бүх улсад л их бага хэмжээгээр Монгол иргэдийн асуудал байж л байгаа. Тэгэхдээ Солонгост илүү түгээмэл учраас ингэж бас оруулж өгсөн байх гэж харж байна. Нэгдүгээрт бас энэ цаг алдалгүй ер нь их төрийн ажил их удаан байдаг. Энэ Солонгосын асуудал нэлээн олон төр дамнаж ингэж явж байгаад энэ парламент дээр бас Хүний эрхийн дэд хороо авч хэлэлцэж байгаад их талархалтай байна иргэдийнхээ өмнөөс.

Миний хувьд энэ Консулын газраас асуумаар байгаа зүйл нь хамгийн нэгдүгээр асуудал нь маш энгийн хэр нь үргэлж тохиолдож байгаа. Жишээлбэл Монгол иргэд эндээс явахдаа мөнгө төгрөгөө, тийзийн мөнгө, визний мөнгө гээд цаг зав гээд өчнөөн л юм болоод очдог. Гэтэл очингуутаа аяллынхаа зорилгыг тодорхойлж хэлж чадаагүй, хэлж чадаагүй гэдэг зүйлээр маш их буцаагддаг юм байна лээ. Ерөөсөө л намайг явж байхад хүртэл дөнгөж онгоцноос бууж ирээд л яах гэж байгаагаа мэдэхгүй.

Гэтэл энэ дунд чинь хэлтэй, хэлэхгүй өчнөөн хүмүүс байж байна. Зүгээр аялах гэж байгаа тэнд бас таньдаг хүн Монголчууд чинь учраа олдог шүү дээ. Очоод таньдаг хүнээ дагуулаад ядаж л дэлгүүр хоршоо орох гэж байгаа тийм хүмүүс ч гэсэн байдаг. Тэгэхээр зэрэг энэ зүйл дээр нь виз олгохдоо жишээлбэл та хэд Солонгосын талд хэлэхдээ визийг нь гаргаж байгаа бол иргэдэд заавал аяллаа тодорхойлох ёстой гэдэг энэ зүйлийг бараг сануулах, сануулсан тохиолдолд тэр хүний хариуцлага болчихож байна шүү дээ. Тэгээгүй тохиолдолд болохоор нөгөө хүмүүс чинь очоод болчихно гээд бодчихдог. Гэтэл очоод буцаагдаад байдаг нэг асуудал байна. Энийг тэр виз гаргахдаа бүүр хавсаргаж болдоггүй юм уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ Монгол гэр бүлүүд яг үнэнийг хэлэхэд хөөрхий ялангуяа залуу гэр бүлүүд энэ гадагшаа явж ажиллах, тэр дундаа Солонгос руу явж ажиллах шугамаар маш их гэр бүлээс салж байна. Нөхөр нь жишээлбэл виз нь албан ёсоор гараад оччихсон, албан ёсоор ажил хийгээд амьдарч байгаа хүмүүс байж байтал араас нь нөгөө төрсөн эхнэр нь хүүхдээ аваад очих тэгэхээр виз нь гардаггүй ийм асуудлууд байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нэгэнт тэр хүн албан ёсоор, хууль ёсны дагуу шаардлагыг хангаад ажиллаж байгаа бол тэр нөгөө гэр бүл нь ч гэсэн харлаж очоод бас дарамт болохгүйгээр визээ аваад хамтдаа амьдрах энэ нөхцөл, боломжоор нь хангах тухай та нар ер нь ийм зүйлүүдийг 2 улсын хоорондын Консулын газар энэ

тэр ярилцаж зөвлөлддөг л байлгүй дээ. Тэгэхээр зэрэг энэ тал дээр анхаарч өгөх хэрэгцээ, шаардлага байгаад байна уу гэж би харж байгаа юм.

Дээрээс нь нэгэнт тэнд ажлын байрны хэрэгцээ шаардлага байна шүү дээ. Тийм учраас Монгол иргэдийг харласан ч хамаагүй аваад ажиллуулаад байна шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ дээр нь бид нар ийм хамтын юу гэдэг юм тэр хүмүүсийг аль болох хууль ёсны биш гээд баривчлаад ингэхийн оронд тэр хэрэгцээ, шаардлагыг нь үнэлээд тэр тохирсон ажил үйлчилгээг нь.../минут дуусав./

С.Эрдэнэболд: Болд дарга хариулъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүнийг асуух асуултад нь нэмчхээрэй.

Б.Болд: Гишүүний асуултад хариулъя. Ер нь бид нар Гадаад харилцааны яамны зүгээс Сөүлд Элчин сайдын яамаараа дамжуулаад иргэддээ энэ анхааруулгыг бас тогтмол хүргүүлж ирсэн. Ялангуяа сүүлийн 2 жил энэ ажлаа нэлээн идэвхжүүлсэн байгаа. Мэдээж иргэд хил дээрээс буцаж байгаа тоотой холбогдуулаад. Саяхан бид нар энэ МИАТ-тай ярьж байгаад нислэгээр явж байгаа улсуудад бас энэ жишээлбэл наад зах нь очоод аяллын зорилгоо тодорхой болгох, очоод холбоо барих хүнийхээ утас шөрмөсийг тодорхой болгох гэдэг ч юм уу ийм мэдээллээ бас тодорхой болгоё гэдэг энэ зөвлөмжийг бас иргэддээ хүргүүлэх чиглэлээр энэ авиа компаниудтай бас хамтарч ажиллах бас энэ ажлыг эхлүүлсэн байгаа.

Энэ гол бид нарын бас ажиллах шаардлагатай нэг юу гэвэл энэ визийн мэдүүлгийн төвүүд байгаа юм. Визийн мэдүүлгийн төвүүд болохоор энэ манай иргэдэд нөгөө виз мэдүүлж байгаа хэлгүй иргэдэд болохоор виз мэдүүлэхэд нь зөвлөгөө өгөөд, зарим тохиолдолд энэ визийн мэдүүлгийн төвүүд хаягаа мэдэхгүй байгаа иргэдэд зохиомлоор ч юм уу бас хаяг энэ тэр бичээд өгчихдөг ийм тохиолдлууд бас байдаг юм байна лээ иргэдтэйгээ уулзаад асуухад.

Тэгэхээр визийн мэдүүлгийн төвүүдтэй бид нар ажиллаад энэ нь иргэдэд зохиомол хаяг өгдөг ч юм уу иймэрхүү юмаа болиоч ээ, энэ чинь болохгүй ээ, энэ чинь иргэд очоод хил дээрээс буцах том шалтгаан болж байна гэдгийг бас хэлж, ярилцаж бас ажиллаж байгаа. Солонгосын талд ч гэсэн бид нар ярьж байгаа. Нэгэнт та нар хил дээр очоод буцаагаад байгаа юм бол жишээлбэл буцах шалтгаан нь тодорхой байсан юм бол яагаад иргэдэд визээ олгоод байгаа юм бэ? Энийг нь та нар систем дээрээсээ шалгаад үнэхээр тухайн иргэн өмнө нь зорчиж байхдаа зөрчил гаргаж байсан байдаг юм уу, аав ээж, ах дүүс нь зөрчилтэй байсан бол ийм иргэдэд виз олгох битгий олгооч ээ. Энэ чинь та хэд олгоод очоод хил дээр очоод буцчихаар давхар энэ иргэдэд бас хохирол учруулаад байна гэдгийг Солонгосын элчинд бас тавьж ажиллаж байгаа.

Ажилчдын гэр бүлийн, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн гэр бүлийн бас хөнгөлөлттэй зорчуулах асуудлыг бас бид нар бас тогтмол тавьж ирсэн. Ер нь Солонгосын талаас манайд яг албан ёсоор хөдөлмөр эрхлэх яг одоогийн байдлаар 3000 квотыг өгсөн байгаа. Тэгэхээр эдгээр яг албан хууль ёсны дагуу хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн бас ар гэрийнхнийг нь зорчиход нь бас хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулаач ээ, визийг нь бас татгалзалгүй өгч байгаа ээ гэсэн ийм хүсэлтийг бас тавьж ирсэн. Яг одоогийн байдлаар Солонгосын тал судалж байна, тодорхой шийдвэр гаргах боломжгүй байна гэсэн ийм хариуг бас өгч байгаа.

Гурав дахь асуудал бол тэр ажлын байртай холбоотой асуудал байгаа. Би сая хэлсэн 3000 квот өгч байгаа. Энэ нь ихэвчлэн хүнд үйлдвэр байдаг юм уу, хөдөө аж ахуйн салбарт ажиллах энэ хүмүүст квот өгч байгаа. Очоод хууль бусаар хөдөлмөр эрхлээд ажиллаад байгаа иргэд маань ихэвчлэн юу гэдэг юм үйлчилгээний салбарт ажилладаг ч юм уу, зочид буудал очоод цэвэрлэгээ хийдэг ч юм уу иймэрхүү салбарт ажиллах нь нэлээн түгээмэл байгаа.

Тэгэхээр бас энэ асуудлыг бид нар яриагүй биш Солонгосын талтай яриад л явж байгаа. Нэгэнт танай талд хэрэгцээ нь байна, манай талаас очиж ажиллах бас хүний нөөц нь байна. Тэгэхээр та нар зөвхөн энэ 3000 квотоор хязгаарлаад хөдөө аж ахуй байдаг юм уу, хүнд аж үйлдвэрийн салбарт энэ юугаа өгөхгүйгээр үйлчилгээний салбартай ажиллах ийм квотыг бас манай улсад зориулж нэмэгдүүлж өгөөч ээ гэсэн ийм хүсэлтийг бас тавиад ажиллаж ирсэн байгаа.

С.Эрдэнэболд: Нарантуяа гишүүн тодруулга.

М.Нарантуяа-Нара: Жишээлбэл өнгөрсөн хугацаанд бага насны өвчтэй хүүхэдтэй Монгол иргэнийг зөрчил гаргасан учраас саатуулахдаа хүүхдийн эрх зөрчсөн гэдэг энэ асуудал явагдаад байгаа. Гадаад харилцааны яамнаас болохоор энэ өнгөрсөн хугацаанд болоод өнгөрсөн асуудал нэгдүгээрт. Иргэд нь жишээлбэл ээж нь ч юм уу, аав нь ч юм уу өөрсдөө зөрчил гаргасан байсан гэж үзэж мэдээлэл өгч байгаа.

Тэгэхээр энэ эцэг эх нь хэрэг, зөрчил гаргасан байлаа гээд хүүхдийг нь давхар шийтгэлд учруулах нь зөв үү? Яг энэ Монгол иргэдийг хэн нэгнийх нь буруутай үйлдлээс болоод үлдэж байгаа, эс үгүй бол хамт дагалдаж явж байгаа, амьдарч байгаа тэр хүүхдүүдийн эрхийг хангах тал дээр танайх ямар ажлууд сайн хийж байна?

С.Эрдэнэболд: Болд захирал хариулъя.

Б.Болд: Гишүүний асуултад хариулъя. Иймэрхүү л тохиолдлууд сүүлийн үед хэд хэдэн удаа гарсан. Хамгийн сүүлийн үеийн жишээ гэх юм өчигдөр, уржигдар бас эгчтэйгээ очсон 15, 16 настай 2 хүүхдийг бас хил дээр саатуулсан ийм хэрэг гарсан байгаа. Ер нь насанд хүрээгүй хүүхдийг ээж, аавтай нь байдаг юм уу, асран хамгаалагчид нь хил нэвтрүүлэхгүй байх тохиолдол гол нь яагаад цуг байлгаад байна вэ гэхээр нөгөө асран хамгаалагчийн л асуудал байгаа. Асран хамгаалагч нь саатуулагдчихсан болохоор насанд хүрээгүй хүүхдийг тухайн улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй байдаг.

Тэгэхээр асран хамгаалагчтай нь байлгаж байгаад буцаахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байгаа. Сая өвөө, эмээтэйгээ явж байгаад бас саатуулагдсан 3 хүүхдийн асуудал гарсан. Энийг манай Элчин сайдын яам Монголд байгаа аав, ээжтэй нь ярьж байгаад, мөн Солонгосын цагаачлалын албатай ярьж байгаад Солонгост байдаг үеэлд нь хүлээлгэж өгөх ийм арга хэмжээг авсан. Өвөө, эмээг нь өмнө нь гаргаж байсан зөрчлийн улмаас хил нэвтрүүлэхгүй.

С.Эрдэнэболд: Баярлалаа асуулт хангалттай, хариулт хангалттай юу? Юугаараа яадаггүй юм байна. Та үг хэлэх боломж байгаа шүү. Сайнзориг гишүүн. Дараа нь та нөхөөд хариулчхаарай.

П.Сайнзориг: Хүний эрхийн дэд хороогоор бас асуудлыг хэлэлцэж байгаа юм байна. Тэгэхдээ би Хүний эрхийн дэд хорооны гишүүд маань бас уг асуудал дээр маш нухацтай авч үзээсэй гэж бодож байна. Энэ манай Байнгын хорооны эрхлэх асуудал мөн үү гэдэг асуудлыг бодох ёстой. Бүхий л энэ Байнгын хорооны асуудлын ард дандаа хүний эрхийн асуудал байгаа юм. Энэ Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороон дээр нэлээн ултай суурьтай яригдах ёстой.

Ер нь аливаа улсын визийг авна гэдэг тухайн ослууд найдвартай зорчино гэсэн баталгаа биш байдаг. Энийг бид хэд улс төржүүлж ерөөсөө болохгүй. Тэгэхээр энэ бид хэд парламентын Дэд хороо ийм зүйлийг улс төржүүлээд байж байгаа нь буруу. Би энэ дээр юу хэлэх гэж байна гэхээр харин бусад улс орнууд энийгээ эрх тэгш байх зарчмын хүрээнд 2 талын гадаад харилцааны бодлогоо нэгтгэж, юун дээрээ алдаа оноогоо ярилцах тэр сувгаа явдаг.

Ер нь глобал паспорт ранкинг/global passport ranking/ гэж байдаг. Энэ глобал паспорт павер ранкинг/global passport power rank/ манай дээр, манай улс өнөөдөр 78 дээр үгүй ээ 68, 69 дээр байж байгаа. Тэгэхээр бид хэд өөрөө энэ улсын энэ гадаад паспорт яагаад хүчирхэг болдог вэ гэхээр тухайн улсын иргэд нь зорчсон улс орондоо гэмт хэрэг үйлддэггүй буцдаг, дээрээс нь тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалдаг. Манай улсын эдийн засгийн нөхцөл байдал муу байгаа учраас манай паспорт бусад улс орнуудад манай улсын иргэдэд тавьж байгаа нөхцөл байдал статус тэгж харагдаж байна гэсэн үг. Тэгж харагдаж байна гэсэн үг.

Тэгэхээр бид хэд энд улс төрчид нь Бүгд Найрамдах Солонгос Ард Улсын ч гэдэг юм уу нэг улсын энэ асуудлыг буруутгаж улс төрийн мэдэгдэл ярьж байгаа нь энэ гадаад харилцааны маш том алдаа болно шүү улс төрчид өө гэдэг зүйлийг би хэлмээр байна. Энэ мэдээлэл чинь явах тусам Монгол Улсын иргэдэд асуудлуудыг чангаруулдаг юм. Битгий ингээч ээ гэж би гуймаар байна. Энэ Монгол Улсын иргэдийн зорчих нөхцөлийг бид нар хангах нь үүрэг боловч энийг чинь бас өөр нөхцөл байдлаар ярьж ингэдэг болохоос биш энэ Солонгос улсын энэ чинь энэ мэдээллүүдийг аваад цаашаа явж байгаа улам манай иргэдээр чангарна Эрдэнэболд даргаа энэ асуудлыг бид хэд ингээд явж байвал. Энэ чинь болохгүй байхгүй юу даа. Бид хэд дараа дараагийн хүмүүсээ хорлоод байна гэсэн үг.

Харин гадаад харилцааны асуудал дээр цаана нь эдийн засгийн харилцаанууд явдаг юм. Энийг бас тойруу замаар хэлж байна шүү. Бид хэлсэндээ хүрэхгүй байгаа байхгүй юу Солонгостоо яриа хэлэлцээний түвшинд хийж байсан тэгнэ ээ гэсэн юмнуудаа. Тийм нөхцөл байдлууд нь цаашаа манай иргэдийн зорчих байдалд нөлөөлж байгаа юм. Дунд нь мэдээж манай иргэдийн бас хариуцлагагүй байдаг юм уу, эсвэл визийн төв нь буруу тэр хаягийг өгчихдөг, эсвэл буруу хаяг бичээд өгчихдөг ийм зүйлүүд бас байгаа юм. Хэдүүлээ ийм зүйлүүдийг хар даа энэ тогтоолыг гаргавал энэ Байнгын хорооны чиг үүрэгт хамаарахгүй. Аюулгүй байдлын бодлогын байнгын хороо. Ер нь ингэж болохгүй ээ. Сэдэв болгоныг барьж аваад хүний эрхтэй наагаад ингээд яваад.../минут дуусав./

С.Эрдэнэболд: Минутаа нэмж өгөх үү? Санаачлагч Бат-Эрдэнэ гишүүн хариулъя. Дараад нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос бас яг энэ хүний эрх талаас нь хариулт өгье. Бат-Эрдэнэ гишүүн.

Үгүй ээ энэ тодорхой хэмжээнд санаачлагчийн байр суурь зайлшгүй хэрэгтэй л дээ. Тийм, тэгэхгүй болохоор та бас нэг талын мэдээлэл өгч байна шүү дээ.

Б.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн энэ юу юм визтэй холбоотой асуудал ерөөсөө хөндөөгүй юм. Тэр 3 дугаар зүйл, заалт дээр 30 хоног хүртэл хугацаанд визний шаардлагаас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх гээд. Энийг бид нар хасуулах саналтай байсан байхгүй юу. Визний асуудал ерөөсөө огт энд хөндөөгүй. Бүгд Найрамдах Солонгос Улс руу нэвтрэх явцад буюу олон улсын транзит зааланд байгаа хүмүүс, Солонгос улсын штамп хилээр нэвтрэх тамга дарагдсанаар Бүгд Найрамдах Солонгос Улсад нэвтэрсэнд албан ёсоор тооцогддог. Тэнд Монгол Улсын иргэдийн гар утсыг үзэх, бүр банкны дата руу орж үзэх маш олон хууль бус үйлдлүүд тэнд явагдаад байгаа юм. Солонгос улсын хилээр нэвтэрч орсны дараахтай холбоотой асуудал бид нар ерөөсөө өнөөдрийн байдлаар хөндөөгүй явж байгаа юм.

Тухайлах юм бол би энэ яагаад зүгээр ийм түвшинд ирчихсэн бэ гэхээр энэ Хүний эрхийн Үндэсний Комисстой холбоотой асуудал. Уул нь энийг бид нар анх Хүний эрхийн Үндэсний Комисст хандсан юм Монгол Солонгосын парламентын найрамдлын бүлгээс. Хүний эрхийн Үндэсний Комисс Бүгд Найрамдах Солонгос Улсын БЭТ шиг ажилласан. Дандаа шалтгаан хэлсэн, олон улсын хууль тайлбарласан. Би зөрүүлээд нэг л зүйлийг асуусан. Яагаад өнөөдөр аялал жуулчлалаар ирсэн Солонгосын иргэн архи уугаад, зодоон хийгээд баривчлагдахад тэнд Элчин сайдын яамнаас нь оройдоо хүрч ирээд хүний эрхийн асуудал буюу танай түр саатуулах байр чинь энэ хүнийг түр саатуулах хэмжээнд тохижилттой биш байна, ийм байна, тийм байна гэж хэлээд аваад гардаг тэр өдөртөө шүү. Яагаад Монгол Улсын иргэд Солонгос улс руу нэвтрэх явцдаа гар утсаа хүртэл үзүүлдэг, банкныхаа дансыг хүртэл үзүүлдэг, мессенжер чатуудаа хүртэл үзүүлж хувь хүний нууцтай холбоотой мэдээллээ алддаггүй бэ гэдэг холбоотой асуудлыг л улам хөндсөн юм. Хүний эрхийн Үндэсний Комисс маань Бүгд Найрамдах Солонгос Улсын БЭТ шиг ажилласан. Би энийг дахин хэлье.

Тийм учраас Хүний эрхийн дэд хороонд албан ёсоор бидний зүгээс бас хандсан. Энэ асуудлыг авч хэлэлцье ээ гээд. Өнгөрсөн удаа бол хэлэлцүүлэг хийсэн. Энэ хэлэлцүүлэг дээр бол Хүний эрхийн Үндэсний Комисст 5 сарын 14-нөөс 5 сарын 31-ний хооронд Хүний эрхийн Үндэсний Комисс дээр ирсэн 9 өргөдлийн дагуу өргөдөл гаргагч нартай албан ёсны уулзалт хийгээд ер нь цаашдаа бид нар Дэд хорооны тогтоол гаргаад явах юм хэрэгтэй юм байна гэж бид нарт өгсөн мэдээллээр бид нар ойлгосон. Бид нар бол энэ визтэй холбоотой асуудлыг хөндөх нь өөрөө энд зарчимгүй үйлдэл ээ гэдгийг бол санаачлагчдын хувьд бол бид нар хэлж байгаа.

Хүний эрхтэй холбоотой буюу Бүгд Найрамдах Солонгос Улсад нэвтрэн орохоос өмнөх процесс дээр л бид нар асуудлыг хөндөөд байгаа юм. Яах вэ ер нь ийм шүү дээ. Та бас таны хэлж байгаатай санал нэг байна эдийн засагтай холбоотой асуудал. 2008 онд Америкийн Нэгдсэн Улс Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 90 хоногийн хугацаатай визгүй зорчих эрхээр хангаж эхэлсэн байхгүй юу. 2008 онд шүү. Одоогоос 17 жилийн өмнө. Тэр үед Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэд Америкийн Нэгдсэн Улсад хууль бусаар оршин сууж байгаа тоо өндөр байсан. Нөгөө талдаа гадаад харилцааны дипломат бодлогын хүрээнд. Ви Даблю Пи/VWP/ гэл үү нөгөө программ байдаг чинь. Тэр программын хүрээнд 90 хоногийн хугацаанд визгүй зорчиж болно. Хууль бус цагаачид хууль бус оршин

сууж байгаа иргэдийн тоог багасгах хүрээнд энэ ажлыг хийгээд Солонгосын иргэд Америкийн Нэгдсэн Улсад хууль бусаар оршин суудаг хэлбэр нь халагдаж байсан байхгүй юу. Бид нар эдийн засгийн нөхцөл байдлыг бол бид нар угаасаа бүгдээрээ л ойлгож байгаа юм.

Гэхдээ бид нар яг хүн амынхаа тоотой харьцуулаад үзэхэд хууль бусаар оршин сууж байгаа 17000 иргэн бол 3.5 сая хүнтэйгээ харьцуулаад үзэхэд 0.43 хувь л байгаа. Манай Гадаад харилцааны яамныхан тэр Солонгост байгаа нөхдүүд ярихдаа юу гэж яриад байгаа вэ гэхээр 54000-тай нь харьцуулж яриад байгаа байхгүй юу.

С.Эрдэнэболд: Ингэе асуулт биш бол үг дахиад авна. Тодруулах юм уу? Тодруулъя.

П.Сайнзориг: Би Бат-Эрдэнэ гишүүнийхээ цаад гол зорилгыг ойлгож байгаа юм, дэмжиж байгаа юм. Монгол Улсын иргэд бас аль ч улс руу зохих журмын дагуу явж байхад хүний эрх нь битгий зөрчигддөг байгаасай. Тэгэхдээ хэдүүлээ аливаа юмныхаа хэмжээ, заагийг бас зөв ойлгож явахгүй бол Солонгос улсын тэр хилийн, агаарын хилийн бүс дэх гэдэг юм уу, тэр онгоцны буудал дахь хилийн бүс доторх асуудлыг Хүний эрхийн Үндэсний Комисс шийддэг асуудал биш байхгүй юу. Аливаа зүйлийнхээ хүрээ хязгаарыг яагаад бид хэд энэ гаралтай харилцааны шугамаараа, дипломат харилцааны шугамаараа энэ асуудлаа ярих ёстой. Хүний эрхийн Үндэсний Комисст хууль тайлбарлалаа гэж буруутгаж болохгүй. Үүний чинь цаана гадагшаа явж байгаа юмнууд нь улам Монгол Улсынхаа бусад иргэдэд дордуулна. Энэ буцаах байдал чинь улам энэ улс төрчид нь хүртэл ингэж Солонгос улсыг нэр зааж буруутгаж байгаа нь бүр болон чангарах бодлого явна. Энийг бид хэд болих ёстой. Энийг харин ярьдаг шугам, хэлэлцдэг тэр албан тушаалтанд үүргээ өгөөд явах ёстой болохоос биш ингэж улс төржүүлж хамаагүй шийдвэр гаргаж болохгүй.

С.Эрдэнэболд: Би бас тодруулгад бас зүйл хэлэхэд энэ ийм байгаа юм. Ерөөсөө энэ Улсын Их Хурлын гишүүний ам бас улс төржүүлж байна гэдэг үг гарахаар л энэ чинь буруу мэдээлэл болчих байхгүй юу. Бид нарын гол шалгуур бол яг энэ хүний эрхийн зөрчил мөн үү гэдэг асуудлаас хохирогчтой уулзсан юм. 14 хоног хохирогчдыг хүлээж авч уулзсан. Хүний эрхийн Үндэсний Комиссоос болохоороо энд бол тодорхой хүний эрхийн зөрчил гэж тооцогдох зүйл байна гэсэн байгаа. Энэ нэгэнт хэвлэл мэдээллээр бас энэ хуралдаан чинь явж байгаа учраас хүмүүст бас зөв ойлголт өгөх ёстой байх, мэдээж бодитой ойлголт өгөх ёс ёстой байх.

Хэрвээ та тэр 3 дугаар зүйл, заалт дээр байгаа тэр визтэй холбоотой зүйлийг хэрвээ горимын санал гаргах юм бол санал хураалтаар хасуулчхаж болно. Түрүүн Сандаг-Очир гишүүн ярьсан шүү дээ гарчиг дээр өөрчлөх үү гэдэг санал хэлсэн шүү дээ. Тэгэхээр тэн дээр ч гэсэн бас горимын санал гаргах юм бол санал хураалтаар шийдэж болно.

Яг энэ дээр хэдүүлээ яая, Хүний эрхийн Үндэсний Комиссоос яагаад яг энэ дээр тодорхой жоохон мэдээлэл өгчихгүй юү Энхболд дарга. Ойлголоо ингээд араас нь үгээ авъя. Яг Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлэл өгчихье. 5 дугаар микрофон. 6 дугаар микрофон Ууганбаатар. Ойлголоо та үгэн дээр хэлчхэж болно. Энхболд дарга.

Б.Энхболд: Би бас тодорхой тайлбар хэлье. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ Бүгд Найрамдах Солонгос Улс дахь иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр энэ бол бас анх удаа яригдаж байгаа зүйл биш 2007 оноос хойш энэ яригдсан энэ гомдлууд бол манай дээр ирж байсан юм байна лээ. Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссоос Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж байгаа иргэдийн хөдөлмөрлөх эрхийн хяналт шалгалтыг хийе гэдэг энэ саналыг тавиад яваад ингэхэд бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тодорхой манайд чиглэл ирсэн байдаг. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс бол зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт Монгол Улсын төрийн байгууллага албан тушаалтны хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах үүргийн хэрэгжилтэд хяналт тавих ийм чиг үүрэгтэй бөгөөд энэ гадаад харилцааны асуудлыг Гадаад харилцааны яамаар дамжуулж асуудлаа олон улсын гэрээ, конвенцын дагуу тавьж ажиллахыг зөвлөө гэсэн ийм албан бичиг ирсэн байдаг. Үүний дагуу бол бид нар гадаадад оршин сууж байгаа иргэдийн гомдол, мэдээллийг бол дандаа Гадаад харилцааны яам, Консулын албаар дамжуулан асуудлыг шийдвэрлэдэг. ийм горимтой бол явж ирсэн байгаа.

Хоёрдугаарт нь манайх Хүний эрхийн Үндэсний Комисс Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой 3 удаагийн санамж бичиг байгуулж хамтран ажиллаж ирсэн ийм туршлагатай. Энэ болгон дээр Солонгосын Хүний эрхийн Үндэсний Комисс бол нэг талдаа бол үүргээ маш сайн биелүүлдэг. Манай комиссоос тавьж байгаа санал, хүсэлтийг бол хүний эрхийн талаасаа бол анхааралдаа авч үзээд асуудлыг хамгийн хэцүү нөхцөл байдалд ч гэсэн шийдэх ийм эрмэлзлийг бол гаргадаг.

Харин эсрэгээрээ манай улсын зүгээс бас үүргээ бид нарын зүгээс бас сайн биелүүлж чадахгүй байгаа. Хамгийн сүүлийн жишээ гэхэд л өнгөрсөн жил ногоон автобусны хэргээр шалгагдсан яллагдагчаар татаад хэрэгсэхгүй болчихсон Солонгос улсын иргэн Монгол улсын хилээр гарч чадахгүй 87 хоноход энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисст хандсан. Бид нар шүүх прокурорт хандахад ямар ч хариу байхгүй байсаар байгаад үндсэндээ бол энэ Солонгосын талд бол бас бид нар комиссын өмнө бол үүргээ бол биелүүлж чадаагүй ийм байдалтай байдаг.

Тэгэхээр энэ юун асуудлууд ярьж байна вэ гэхээр бид нар энэ асуудлыг бол хүний эрхийн механизмуудаар дамжуулж бас тавих ийм боломж бол байдаг нь хамгийн үндэслэлтэй арга юм байна лээ. Одоо тэр Юү Пи Ар/UPR/-ийн тайлан, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын тайлан дээр Монгол Улс мэдээллээ НҮБ-ын хүний эрхийн хороо руу албан ёсоор ингэж гаргавал тэр хүний эрхийн гэдэг юм уу, тэр нөгөө хүнлэг бус орчинд хориод байгаа, саатуулаад байгаа, хүүхдийн эрхийг зөрчөөд байгаа асуудлыг НҮБ-ын Хүний эрхийн хороо Солонгостой албан ёсоор ингэж яривал энэ нь илүү их үр ашигтай ийм механизмууд бас болох талтай байдаг юм байна лээ гэдгийг тайлбар хэлье.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүдээс санал хэлэх, үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би бас Сайнзориг гишүүний бас хэлээд байгаа саналыг бас Хүний эрхийн дэд хороо дарга нар бас бас анхаарахгүй бол 2 улс орны хоорондын гадаад харилцаанд бас бид нар янз бүрийн сөрөг байр суурь гаргачих вий дээ гэсэн ийм болгоомжлол байна. Энэ тогтоолын төсөл ер нь Гадаад харилцааны яам энэ ажлын хэсгийнхэнд тараагдсан уу үгүй юу, үзсэн үү үгүй юу? Энэ Гадаад харилцааны яам энэ тогтоолын төсөл дээр ямар байр суурьтай байгаа юм? Энийг бас та нар маань авч үзэж харахгүй бол бид нар Хүний эрхийн дэд хороо гээд эндээ авч үзэж байдаг Гадаад харилцааны яам энийг огт мэдээгүй байж байж болохгүй шүү. Асуудлын уг учгийг ойлгоод байгаа. Солонгос улс дахь Монгол Улсын иргэд олон хүний эрхийн зөрчлийн асуудал үүсэж байгааг.

Гэхдээ Сайнзориг гишүүний яриад байгаа юм нь өнөөдөр яг бид нарын авч хэлэлцэх манай Байнгын, Дэд хорооны хэлэлцэх асуудал мөн үү үгүй юу? Нөгөө талаар энэ чинь тогтоолын төсөл гарчгаасаа халиад явчихсан байна гэж харах гээд байна. Би жишээ нь 2 дахь заалтыг та бүхэн хараарай. Энэ чинь уг нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар авах гэж байгаа арга хэмжээ шүү дээ. Тэгсэн чинь парламентын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг болон парламентын хууль тогтоомжийн хэрэгжилтэд гэж юу юм гэдгээс авхуулаад, тэгээд Төлөөлөгчийн газар, Консулын албаны хариуцлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Элчин сайдын яамдын үйл ажиллагаанд шалгалт, мониторинг хийх, гадаад харилцааны болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар холбогдох Засгийн газрын гишүүдээс тайлбар авч, санал, дүгнэлт боловсруулах гээд нөгөө хүний эрхийн асуудал ярьж байсан чинь одоо бүр Элчин сайд, дипломатын газрын үйл ажиллагаанд шалгалт хийнэ, Засгийн газрын гишүүдээс нь тайлбар авна эд нар гээд үндсэн агуулгаасаа хальчихсан ийм заалт өгүүлбэрүүд байна шүү.

Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр ер нь энэ тогтоолыг ахиж авч үзэж, ахиж нарийн сайн үзэхгүй бол үнэхээр энэ яриад байгаа 2 улсын хоорондын харилцаанд сэв суулгасан гэдэг юм уу, хүний эрхийн хүрээнд, нэрийн доор ийм асуудал үүсгээд цаашдаа бүүр улам чангаруулчих вий дээ, сөрөг байдал үүсгэхэв үү дээ гэсэн ийм болгоомжлол байна шүү. Тийм учраас би энэ асуудлыг ахиж авч хэлэлцэж, тогтоолын төсөл дээрээ ахиж сайн суух шаардлагатай юм байна гэж хэлэх гэж байна. Тийм.

С.Эрдэнэболд: Бат-Эрдэнэ, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. 2012 оноос Гадаад харьяат дээр ажиллаж байсан Пүрэвдорж дарга өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн яг Солонгосын хил дээр хэдэн Монгол хүнийг буцаана тэр өдөрт нь Монгол Улсын хил дээрээс төдий тооны Солонгос иргэдийг буцааж байсан тохиолдол байсан. Элчингийнхэн би сонсоосой гэж хүсэж байгаа юм. Сонсоосой гэж хүсэж байгаа юм. Яагаад тэр үед хил дээрээс буцааж байсан Монголчуудын тоо багассан гэж ярьдаг. Багассан гэж ярьдаг. Энэ дээр бол тухайн үед ч тэр бид нар бас эсэргүүцэж байсан ингэж болохгүй ээ гэж.

Өнөөдөр Бүгд найрамдах Монгол Улс Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг аялал жуулчлалын чиглэлээр визгүй зорчуулж байгаа. Гэхдээ аялал жуулчлалын чиглэлээр. Бизнес эрхлэх олон дахин давтамжтай орж ирж байгаа иргэдийг Монгол Улсын хил дээрээс бас буцааж байгаа. Энэ бол нөгөө талдаа бас л бид нар аялал жуулчлалын жил зарласантай холбогдолтойгоор зөрчилдөөд байгаа ч юм шиг асуудлууд үүсэж байгаа юм.

Ер нь өнгөрсөн хугацаанд бид нар ийм ёс, төлөвшил гэдэг юм уу, ёс суртахуунаа бид нар барьж ирсэн л дээ. Нөгөө талдаа бид нар ийм сул дорой байдлаа өнөөдрийг хүртэл бид нар илэрхийлж ирсэн. Бид нар энд ийм юм ярьчихаар тэнд тэгчих вий дээ, энд Улсын Их Хурлын гишүүн юм ярьчихаар тэнд ийм асуудал үүсчих вий дээ гэдэг ийм асуудлууд. Би бол Байнгын хорооны гишүүн биш, Дэд хорооны гишүүн биш Монгол Солонгосын парламентын найрамдлын бүлэгт бас тодорхой хэмжээний саналууд ирсэн учраас Хүний эрхийн Үндэсний Комисст хандсан. Хүний эрхийн Үндэсний Комисс маань би бол ажлаа муу хийсэн гэж дүгнэж байгаа.

Ийм учраас цаашлаад Хүний эрхийн дэд хороонд хандсан. Дэд хороо асуудлыг аваад хэлэлцэж байгаа. Дэд хорооны гишүүд маань өөрсдийнхөө байр сууриар шийдвэрлэнэ биз дээ. Гэхдээ эцэг эх, асран хамгаалагчгүй хилээр нэвтрүүлж байгаа насанд хүрээгүй 3 хүүхдийг та нар бодоорой. Өнөөдөр Солонгос хүний эрхийг Монгол Улсад дээдэлдэг мөртөө Монгол хүний Солонгос дахь эрхийг дээдэлдэг, Монгол хүнийхээ төлөө ажилладаг байгууллагагүй байгаа шүү. Ний нуугүй хэлэхэд. Би 4 сард Солонгост очсон. Элчин сайдын яаман дээр байж байхад утсаар ярьж байгаа юм. Нөхрийг нь буцаачихсан, аав, ээж нь байхгүй жирэмсэн эмэгтэй тэр өдөр төрөх гээд ганцаархнаа гэртээ байж байх жишээтэй. Уйлаад хайлаад бөөн юм болж байгаа юм.

Гэтэл Элчин сайдын яам нь өөрөө 17-хон хүнтэй байх жишээтэй. Гэтэл нөгөө талдаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зөвхөн дарга нарын хамаатан садныг томилдог хөдөлмөр эрхлэлт буюу 3000 орчим гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн эрх ашгийг хамгаалах тал дээр ажиллаж байгаа 23 албан хаагч байгаа. Зөвхөн сайдын тушаалаар байгуулагдсан. Өнөөдөр Жаргалмаа гэдэг гишүүн Улсын Их Хурлын гишүүнээсээ буугаад тэнд очоод ажиллаж байна. Энэ зарчим юм уу?

Сайнзориг гишүүний зарим ярьж байгаа юмтай би санал нийлж байна. Бид нар зарчмаа ярих ёстой. Гэхдээ Хүний эрхийн дэд хороогоор орж байгаа энэ асуудлыг Гадаад харилцааны яам, Хүний эрхийн Үндэсний Комисс авч үзээд саналаа илэрхийлсэн болов уу гэж ойлгож байгаа. Энэ дээр хэрвээ та бүхэн маань саналаа хэлээгүй байгаа бол Сандаг-Очир гишүүний хэлсэнчлэн бүрэн эрх нь та бүхэнд маань байгаа. Бид нарын хувьд бол Монгол Солонгосын парламентын найрамдлын бүлэгт ирсэн саналыг үндэслээд, иргэдийнхээ санал дээр үндэслээд энэ асуудлуудыг та бүхэнд танилцуулж бас явж байгаа юм шүү гэдгийг илэрхийлэхийг хүсэж байна. Баярлалаа.

С.Эрдэнэболд: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр Монгол Улсын иргэнийхээ асуудалд Монголын төр үүрэг хариуцлага хүлээж иргэнийхээ төлөө явахгүй юм бол хэн явах юм? Бид нар энд юу хийж сууж байгаа юм? Хүний эрхийн дэд хороо гэж энэ наад захын иргэнд тулгамдаад байгаа энэ асуудал бэрхшээлийг шийдэхийн төлөө ажиллахгүй юм бол бид нар энд үхсэнээ хийж суух юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ агуулгын, тогтоолын төсөл дээрх агуулгын зарим юмнуудаа яах вэ янзалчихна биз. Энэ асуудлыг бид нар энд хэлэлцэх нь зүйтэй шүү дээ. Гэхдээ бид нар энд Солонгос Улсын гадаад бодлого ямар байх тухай үүрэг чиглэл өгөх гээд байгаа, Солонгосын Элчин сайдад чиглэл үүрэг өгөх гээд байгаа хэрэг

огт биш. Нэгэнт бидний Монгол Улсын иргэний нийтлэг олон иргэдэд тохиолдоод байгаа асуудал энэ мөн бол бид нар энэний тухай авч хэлэлцэж, явал нааштай байх вэ, явал зөв, сайн шийдэх вэ гэдгийг ярилцах нь энэ бидний үүрэгт ажил.

Хоёрдугаарт энэ жишээлбэл яагаад Монгол Улсад Солонгос иргэний эрх зөрчигдөхөөр элч нь ирээд өдөрт нь авчихдаг мөртөө Солонгос улсад, мөн хил дээр болон энэ аливаа нөхцөлд Монгол Улсын иргэдийн эрх зөрчигдөхөд энийг хэн ч авч хэлэлцэхгүй хохирсон хүмүүс дараа нь сошиалаар шуугиад байна гэдэг чинь бид нар өөрөө өөрсдийгөө хэрхэн, яаж үнэлж, хүндэлж, дээдэлж байгаа юм, бид нар өөрөө өөрсдийнхөө төлөө хэрхэн яаж явж байгаа юм, Монгол хүний үнэ цэн гэдэг юм хаана байгаа гэдэг нь л тодорхойлол. Яг үнэндээ эдийн засгийн асуудал байдаг л юм байгаа биз. Гэхдээ тэглээ гээд энэ Монгол зүгээр энэ явж байгаа, зорчиж байгаа, ирж очиж байгаа, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа үгүй ээ хууль зөрччихсөн байсан ч гэсэн тэр хүнд эрх байгаа шүү дээ.

Тэгэхээр яагаад ийм байна вэ гэдэг чинь ерөөсөө л Монгол Улс өөрөө иргэнээ ямар түвшинд үнэ цэнтэй байлгадаг вэ гэдгийн л илрэл байхгүй юу даа Сайнзориг гишүүн ээ. Тэгэхээр бид нар энийг энд ярихгүй юм бол өөр хэн ярих юм? Үгүй ээ тэгээд энэ хар аа энэ сая хэлж байна. Тэр Жаргалмаа, хуучин гишүүн Жаргалмаа гишүүн тэнд 20 хэдэн бүтэцтэй үндсэн Элчин сайдынхаа юунаас илүү том бүтэцтэй. Тэр хүмүүс тэнд юу хийж байгаа юм? Тэр хүмүүс тэнд Монгол Улсын хөдөлмөр эрхэлж байгаа бүх түвшний хүмүүсийн эрх ашгийг хамгаалах гээд сууж байгаа биз дээ? Гэтэл тэнд Монгол эмэгтэй ажлын байран дээрээ хүчиндүүлээд, хүчирхийлүүлээд, зодуулаад, цалин хөлсөө авч чадахгүй ингээд явахад тэр хүмүүс очиж тэр хүмүүсийн эрх ашгийг хамгаалах ёстой биз дээ? Гэтэл нөгөө Монгол иргэд чинь хөөрхий нэгдүгээрт айдастай байна, зарим нэг нь хууль бусаар ажиллаж байгаа баригдаад явна гээд зөндөө олон айдсууд байгаа.

Гэхдээ ямар ч айдастай байсан тэр хүн ажилласан бол цалин хөлсөө аваад Монгол эх орон руугаа буцах ёстой. Энэ эрх ашгийг бид нар буюу бид нараар дамжуулж тэнд томилогдож байгаа хүмүүс чинь л хамгаалах ёстой биз дээ? Бид нар жишээлбэл энд яагаад энд тэнд бүртгэл гарна гээд л л айгаад л хулмайгаад суух ёстой юм. Бид нар энэ Монгол иргэдийнхээ асуудлыг ярилцаад аль болох нааштай шийдэх хамтын ажиллагааны хүрээнд энэ асуудлаа тусгая л даа. Зөвлөмж жишээлбэл виз гарахдаа хүртэл тэр зорилгоо тодорхойлж чадахгүй байгаа бол яах ёстой юм гэдэг энэ санамжийг нь заавал авиа компаниудаар биш, жишээлбэл энэ 2 улсын гадаад бодлого дээр ярилцаад иймийг бүүр санамж болгоод оруулъя гэдэг ийм энгийн зүгээр шийдлүүд бас байж болно шүү дээ. Тийм биз дээ?

Тэгэхээр энэ Монгол Улсын иргэнийхээ ас асуудлын бид нар хөндөж ярьж, бид нар энд явал нааштай шийдэх вэ гэдэг дээр фокуслахгүй юм бол өөр хэн ч тэд нарын төлөө явахгүй шүү дээ.

С.Эрдэнэболд: Сайнзориг. Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Би улс төрчид байр сууриудаа тодорхой хэлээд явахад асуудал байхгүй. Түрүүн Пүрэвдорж даргын нэрийг ч татаад хэлж байна. Манай Бат-Эрдэнэ гишүүн ч хэлж байгаа. Би Бат-Эрдэнэ гишүүнийхээ ерөнхийдөө чин зорилгыг ойлгоод байгаа юм. Тэгэхдээ ийм асуудлуудыг ултай суурьтай суурилж гадаад харилцааны асуудал чинь маш эмзэг байдаг байхгүй юу. Маш эмзэг байдаг. Энэ Монгол Улсын цаашдаа гуравдагч орон руу гардаг гол бас агаарын

боомттой байдаг Улаанбаатараас Инчоны чиглэл рүү, Улаанбаатар хот, дээрээс нь Солонгос улс манай гуравдагч хөрш, эдийн засгийн түнш хувьд нэлээн өндөр харилцаатай.

Хоёрдугаарт бид нар бас хүнд цаг үе дээр манай иргэдийг бас авч ажиллуулж байсан түүхтэй. Солонгосчууд яах вэ бид нар байгаа зөвхөн 17-хон мянган иргэн шүү дээ гээд байдаг. Энэ 17 мянган иргэд чинь нийт Монгол Улсын зорчиж байгаа иргэдийнхээ хувьд яахаар өндөр үзүүлэлт байхгүй юу. Энэ ажил чинь багасгачихвал манай иргэдийн зорчих эрхийн асуудал арай бас өөрөө шийдэгдэнэ гэдэг. Солонгосчууд 1 улсад зориулж гадаад бодлогынхоо буюу зарчмыг алдагдуулж чадахгүй гэдгээ албан ёсоор хэлдэг байхгүй юу хэлдэг.

Тэгэхээр бид хэд энэ Нара гишүүний хэлээд байгаа юмыг чинь тогтоол гаргаж биш энэ дээрээ бид нар зохион байгуулалтын арга хэмжээ авч, холбогдох дипломат албаны хуулийг хэрэгжиж байна уу үгүй юү гэдэг дээрээ холбогдох Байнгын хороо нь хэлэлцээд явдаг болохоос бид хэд ингэж Хүний эрхийн үндэсний дэд хороонд хамааралгүй асуудлаар, гадаад оролцооны асуудлаар 1 орныг нэр зааж буруутгаж маягтай өнгө аястай орчхож байгаа байхгүй юу. Ийм тогтоолыг гаргана гэдэг бол бид хэд гадаад харилцаан дээрээ маш том алдаа гаргах гэж байна. 1 орныг хүний эрх зөрчигч орон гэж бид нар зарлах гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ болохгүй ээ. Би энийг асуудлуудыг би ойлгож байгаа шүү. Би Монгол Улсынхаа иргэдийг визээ аваад бусад орон руу чөлөөтэй зорчдог байгаасай. Тэнд зорчихдоо хүний эрх битгий зөрчигддөг байгаасай. Энэ дээр манай Гадаад харилцааны яам болон холбогдох байгууллагууд идэвх чармайлт гаргаж ажилладаг байгаасай. Байнгын ярьж байгаа шүү дээ. Гадаад харилцааны Монгол Улсын иргэд их олноор зорчдог орнууд руу орон тоог нь нэмж өгөөч ээ гэдэг. Өнөөдөр Оросын Холбооны Улсын Элчин сайдын яаманд хэчнээн орон тоо байдаг гэлээ. Баахан объект худалдаад авчихсан. Объектуудын манаачаар ажилладаг гэж байгаа байхгүй юу.

Гэтэл Солонгос руу Монгол Улсын эдийн засаг гадаад харилцааны төв болсон Швейцарын Женев хотод, НьюЙорк-д ч гэдэг юм уу яг Монгол Улсын эрх ашгийг яригддаг олон улсын тренд хандлагууд юу хаашаа чиглэж байгаа талаар сонсдог газруудад ерөөсөө 8-хан хүнтэй, 11-хэн хүнтэй байж байгаа шүү дээ. Би Гадаад харилцааны яам жишээ нь Женевийн Оюуны өмчийн байгууллага дээр хүн томилооч. Ингэж байж бид нар энэ дэлхийн эдийн засгийн чиг хандлага хаана явж байгааг илтгэнэ. Энэ эцсийн дүндээ бид хэд, би яагаад энийг сайн мэдээлэлтэй байдаг вэ гэхээр би бас Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байхдаа Солонгосын холбогдох газруудтай хэлэлцээр хийж, асуудлууд хаанаа гацаж байгаа гэдгийг би мэдэж байгаа юм. Энд хэлж болохгүй байна. Өөр зүйлүүд байдаг юм. Монголын бас нөгөө эдийн засгийн секторын хамтын ажиллагаа дээр бид хэд ярьсан, хэлсэндээ байдаггүй маш олон зүйлүүд байдаг.

Хоёрдугаарт бас бид хэд иргэддээ түрүүн Нарантуяа гишүүний хэлж байгаа шиг зөв мэдээллийг өгөх. Энэ нь сүүлдээ гадаад харилцааны асуудал болдог. Одоо зорчиж байгаа иргэд маань харин бүр Солонгос дээр олноороо буцдаг болчих вий дээ. Ийм л үр дүн, дагавартай юмнуудыг бүхэл бүтэн парламентын албан ёсны шийдвэр болж гаргах гэж байна шүү Эрдэнэболд даргаа. Юманд бас хүний эрх гэж бас хандаж болно. Тэгэхдээ аливаа зүйл дээр бас зарчимтай ханддаг байгаарай гэж хүсмээр байна.

С.Эрдэнэболд: Уянгахишиг гишүүнд микрофон өгье.

Г.Уянгахишиг: Өнөөдөр бид нар маш чухал асуудлыг хэлэлцэж байгаа. Тэгэхээр уг нь Сайнзориг гишүүнийг бас сонсчхоосой гэж бодсон юм. Ер нь бол бид нарын мэдээж яг найруулгын хувьд буюу үг, үсэг, чиглэсэн хандалт тал руугаа бид нар засах хэд хэдэн зүйлс ажиглагдаж байна. Тэрнээс үндсэн яг агуулгын хувьд бол энэ өөрөө илүү юу гэдэг юм гадаад улсын гэдэг юм уу, Солонгос улсын байгууллагууд руу дайрсан ч гэдэг юм уу, эсвэл тэнд хүний эрхийн зөрчил үүсэж байна гэдгийг баталгаажуулсан ч гэдэг юм уу тийм агуулгаар биш. Бидний хувьд Монгол Улсын иргэнийхээ хүний эрхийг хангах тал дээр тэн дээр зөрчил үүсэж байна уу, үгүй юү гэдэг тал дээр, нөгөө талаасаа энэ хүний эрхийн зөрчил хангах энэ асуудлууд юу гэдэг юм 2 улсын хоорондох асуудал гэхээсээ илүүтэйгээр тухайн хувь хүмүүсийн тэр нийгмийн харилцаан дахь орж ирж байгаа асуудлууд энэ болгон дээр Монгол Улсыг төлөөлж суугаа Элчин сайдын яамнууд, Монгол Улсыг төлөөлж байгаа албаны хүмүүс, Консулын үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэднээс мэдээлэлтэй байлгах энэ тал руугаа Засгийн газарт үүрэг өгч байгаа нь бас тийм болохгүй зүйл биш харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ талаасаа нэгэнт Хүний эрхийн дэд хороо гэж байгаа, Хүний эрхийн дэд хороонд гомдол, саналууд, хүсэлтүүд ирж байгаа тохиолдолд бид нар арга хэмжээ авч ажиллахаас өөр арга байхгүй.

Нөгөө талаасаа Засгийн газар, Гадаад хэргийн яам, яг гадаад, дотоод асуудал энэ бодлогын шинжтэй асуудлуудыг бид нар ойлгож байгаа. Яг тэр бодлогын шинжтэй гадаад бодлогын асуудал руу бид нар нөлөөлж орохгүй. Яг энэ агуулгыг ч гэсэн сая уншаад үзэхэд бол айхтар тэгж нөлөөлж орох гэсэн тийм шинжтэй агуулга харагдахгүй байна л даа. Тэгэхээр энийгээ бид нар ямар ч байсан мэдээллийг гаргаж өгөх, дүн шинжилгээ хийх, буцаад энэ асуудлууд дээр анхаарал тавьж ажиллах энэ тал руугаа бол бас үүрэг, даалгавар өгөөд явах нь зүйтэй байх гэж харж байна. Энэ дээр бас гишүүд маань буцаад яг бид нар бол санал хураалт дээрээ яг энэ текстээр авъя гэж байгаа юм байхгүй тийм ээ? Яг энэ текстийг редакцын засвар хийгээд, нөгөө талаасаа бас яг энэ 3 дахь асуудал дээр буюу Хүний эрхийн Үндэсний Комисст даалгаж байгаа даалгаврын тухайд би сая уг нь Хүний эрхийн Комиссоос тодруулмаар байгаа юм.

Өөрөөр хэлбэл, Хүний эрхийн Комисс чинь өөрөө яг Монгол Улсын байгууллага гэхээсээ илүүтэйгээр олон улсын байгууллагын хүрээнд өөрийн чиг үүрэгтэй, эрхтэй, хамтын ажиллагааны зарчимтай явдаг. Тэгэхээр яг Хүний эрхийн Комисс ийм байдлаар энэ даалгаврыг хэрэгжүүлж ажиллах боломжтой юу, үгүй юү гэдэг дээр бид нар бас саналыг сонсох ёстой.

Нөгөө талаасаа яг олон улсынхаа гэрээ, хэлцлийн дагуу ямар байдлаар ажиллах боломжтой юм бэ гэдэг бас саналуудыг нь сонсох ёстой болов уу гэдэг ийм саналтай байгаад байна.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Би энэ Дэд хорооны даргын хувиар бас хоёрхон өгүүлбэр хэлье. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг гишүүн өөрөө гарчихлаа. Гэхдээ нэгэнт энэ хэвлэл мэдээллээр бас энэ хуралдаан явж байгаа учраас нэг зүйлийг хэлэхэд энд Улсын Их Хурлын гишүүд ямар нэгэн байдлаар улс төржиж байгаа асуудал огт байхгүйг хариуцлагатайгаар хэлье.

Хоёрдугаарт, Монгол Солонгосын бүлгэмийн дарга Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн Солонгосын хил дээр буцаагдсан иргэдийн гомдлыг албан ёсоор бас бид нарт тавиад өнгөрсөн сар Хүний эрхийн Үндэсний Комисс дээр 14 хоногийн хугацаанд нийт хохирогчдыг хүлээж авч уулзаад, өмнөх долоо хоногийн яг энэ өдөр хохирогчдын төлөөлөлтэй талууд шийдвэр гаргах түвшний байгууллагууд уулзаад өнөөдрийн тогтоол санаачлагдаж гаргаж ирж байгаа Сандаг-Очир гишүүн ээ Гадаад харилцааны яам, Хүний эрхийн Үндэсний Комисс гээд.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын нэг чиг үүрэг чинь өөрөө хяналтын чиг үүрэгтэй. Энэ баталсан хууль тогтоомжууд хэрэгжиж байгаа хэсэг дээр. Тэгэхээр бид нар зөвхөн Улсын Их Хурлын зүгээс Засгийн газартаа л энэ асуудлыг судалж үзээч ээ гэдэг л чиглэл энд байгаа болохоос биш Бүгд Найрамдах Солонгос Улс буюу өөр улсын аливаа нэр төрд нь халдсан, үгүйсгэсэн, үл хүндэтгэсэн, дипломат харилцаанд сэв суулгах 1 ч үг, өгүүлбэр, санаа зорилгын цаасан дээр тогтоолын төсөл дээр байхгүй байгаа. Түрүүн Сандаг-Очир гишүүн бас хэлж байна лээ. Тэгэхээр энэ дээр бол ерөөсөө тийм агуулга байхгүй байгаа.

Гуравдугаарт, бид Үндсэн хуулийн өмнө Монгол Улсын иргэдийнхээ нийтлэг эрх, ашгийн төлөө тангараг өргөсөн. Тэрнээс биш аль нэг улсыг тэгж бодож магадгүй, ингэчих вий дээ гэдэг байдлаар бид нар бол эрх ашгийн эрэмбээ зөв харах ёстой шүү дээ. Тэгэхээр Монгол хүний эрх ашиг хаана зөрчигдөж байна тэнд эрхийн зөрчил байна уу, тэнд гадаад, дотоод гэхгүй бид улс юм чинь ажиллах ёстой гэдэг энэ зарчмаар энэ төсөл, тогтоол санаачлагдаж байгаа.

Мөн бас тэр 3 дугаар зүйл дээр байгаа асуудал чинь өөрөө 2 улсын хооронд яригдаад шийдэгдэхгүй яваад байгаа зүйл учраас энэ дээр чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх гэдгийг л чиглэл зааж оруулж байгаа зүйл юм. Энэ хууль давсан дүрэм журам огт биш. Зүгээр хуулиа хэрэгжүүлэхийг зөвлөж байгаа, нэг талаасаа шахаж байгаа зүйл.

Эцэст нь хэлэхэд бол Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний хэлсэн бас саналтай байр суурь нэг байна. Гэхдээ бид ер нь юугаа хийх гэж энд сууж байгаа юм, Хүний эрхийн дэд хороо гэдэг энэ бүтэц ийм булчирхай ч биш, энэ чинь ажилладаг систем байх ёстой шүү дээ. Энэ дээр ямар нэгэн байдлаар асуудал гарахаар энийг улс төржүүлээд байна гэдэг байдлаар хандаж огт болохгүй байх. Монгол хүний эрх ашиг хаана зөрчиж байгаа энэ дээр бас асуудал бид нар дандаа шийдэл рүүгээ ярьж байх ёстой. Тэр утгаараа бол энэ тогтоолын төслийг редакцтайгаар батлахыг бас би та бүхэндээ уриалж байна. Редакцтайгаар батлахыг уриалж байна. Энэ дээр бас Сандаг-Очир гишүүний санаа болон Уянгахишиг гишүүний санаануудыг тусгаад Гадаад харилцааныхаа яам эд нартай цаашаагаа хамтраад явъя. Энэ чинь олон хүн хүлээж харж байгаа зүйл шүү дээ. Тэгэхээр бид нар Монгол хүний эрхийн асуудалд хариуцлагатай хандъя л гэдэг бодолтой байна.

Бас бүхэл бүтэн 35 хүнтэй Монгол Солонгосын Найрамдлын бүлгэмээс энэ санал ирчихсэн. Парламентын 126 гишүүний дөрөвний нэгээс илүү нь энэ бүлгэмд байгаа байхгүй юу даа. Тэгэхээр парламентын маш олон гишүүд энэ дээр бас саналаа өгч байгаа тийм ээ? Тэр утгаараа бол бид нар энэ дээр зүгээр тэгсхийгээд өнгөрөөж болохгүй байна. Яг тэр визтэй холбоотой нарийн ширийн асуудал дээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бусад тэр юмнуудаар явах нь явах л биз. Бид нар энэ дээр зөвхөн хүний эрх гэдэг зүйлийг л авч байгаа.

Түрүүн үндэсний Комисс хэлсэнгүй л дээ. Уг нь би хэлчээсэй гэж бодож байсан. Яг Хүний эрхийн Үндэсний Комисс тэр иргэдтэй уулзаад үзэхээр яг үндсэн 5 төрлийн хүний эрхийн зөрчил байна гээд бүүр манайхан дүгнэлт гаргаад уулзчихсан байхгүй юу. Тэрийгээ бас сайн хэлэхгүй болохлоор улс төржөөд байна гэдэг өнцөг бас харагдаад байна шүү дээ.

Эцэст нь хэлэхэд бол бид тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд өөрийн иргэнээ хаана ч хамгаалах төрийн үүргийг хэрэгжүүлэхийн тулд энэ тогтоолын төслийг дэмжиж өгөөч ээ гэж та бүхнээс хүсье.

Тогтоолын төсөлтэй холбоотой санал Хишигдэмбэрэлийн Тэмүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Энэ тогтоолын төсөлд нэг ийм заалт нэмж болох уу? Ер нь Монгол Улсын иргэд хамгийн ихээр зорчдог, гэмт хэрэгт өртдөг, холбогддог, эс үгүй бол хүний эрх гэдэг юм уу энэ асуудалд асуудал нь хөндөгддөг ийм зарим нэг улсад Монгол Улсын зүгээс хууль зүйн атташе томилох асуудлаа шийдэх ёстой байх. Одоо энэ хууль зүйн атташегийн тухай яриа 24 дэх жилдээ болж байна шүү дээ. Ер нь энэ манайд чинь улс дамнасан гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд нэлээн их орж ирдэг болчихлоо. Хүн худалдаалах, хар тамхи, цахим залилан гэх мэтчилэн, хөдөлмөрийн мөлжлөгт ч өртөх магадлал ихтэй болчихлоо. Энэ бол дэлхийд байгаа бүх улстай холбоотой биш ерөөсөө манай улсын иргэдийн байнгын, олноороо зорчдог 5, 6 улс дотор харагдаж эхэлж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дипломат төлөөлөгчийн газруудад тухайлбал, энэ онц шаардлагатай байгаа 5, 6 улсад хууль зүйн атташе бий болгох замаар иргэнийхээ эрхийг хамгаалах, тухайн улсын хүний эрхийн болон хуулийн байгууллагуудтай хамтарч ажиллах, боломжийн энэ улс хоорондын гэрээ, хэлцэл байгаа бол тэрийг амилуулах боломжтой ийм шинэ бүтэц бий болгох энэ чиглэлээр тийм үг, өгүүлбэр орчихвол зүгээр байна.

С.Эрдэнэболд: Байнгын хорооны ахлах зөвлөх бас юу зөвлөж байна. Бид нар агуулгаар нь энэ тогтоолын төслийг дэмжчихэнгүүт яг таны саяын хэлсэн саналыг багтаагаад, дээрээс нь тодорхой хэмжээгээр үг, үсгийн, логикийн зөрчил гаргахгүйгээр редакциягаар батлаад явчхаж болно гэж байна. Тэгэх юм бол түрүүний Сандаг-Очир гишүүний саналыг ч гэсэн багтаагаад, Тэмүүжин гишүүний саяын санаачилгыг 1 параграф буюу зүйл нэмж багтаагаад батлаад явчихъя гэж байгаа юм.

Бид нар энийг хойшлуулдаг ч юм уу, дахиад л ажлын хэсэг гаргаж болно л доо. Гэхдээ дахиад л хугацаа алдана. Дахиад л өчнөөн хүний эд хөрөнгө, тэр чинь хөөрхий байгаа байхгүй юу. Энд ирээд уулзсан хүмүүс бид нар ядаж тал хохирлоо гаргачихмаар байна гэсэн асуудал.

Ингээд санал хураалт эхэлье. Санал хураалтад бэлдье нээрээ шинэ юугаараа. Саналаа хураачихъя.

Дэд хорооны тогтоолын төслийг саяын хэлсэн Улсын Их Хурлын гишүүдийн саналыг тусган батлахыг санал хураалт явуулъя дэмжье гэж байгаа. Протоколд Сайнзориг гишүүнийг, Пүрэвжавын Сайнзориг гишүүнийг ирцээс өөрийнх нь саналын дагуу хасъя. Санал хураалтад оролцохгүй. Нэмэн эерэг, сөрөг саналд тооцогдохгүй гэсэн саналыг протоколд тусгая. Санал хураалт эхлүүлье. Санал

хураалт дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Цаана компьютерын хүн энэ үгийг хүлээгээд байх шиг байна. Санал хураалтаа явуулаарай.

Сайнзориг гишүүнийг протоколд санал хураалтад оролцоогүй ирцээс хасаад 7 гишүүнээс 5 гишүүн дэмжсэн байна. Ингээд редакцтайгаар тогтоолын төсөл батлагдлаа.

Хурлаа ингээд хаая. Дэд хорооны өнөөдрийн хурлыг хааж байгааг мэдэгдье.

Хурал хаачхаад 2-хон минут Тэмүүжин гишүүн ээ ингэсэн юм. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан гишүүн Хүний эрхийн дэд хороонд ийм хүсэлт ирүүлсэн. Энэ хүсэлтийг та бүхэнд тараагаад өгчихсөн байгаа. Тийм, талбай дээр үсээ хусаад эсэргүүцэл илэрхийлж байгаа хохирсон иргэдийн ийм асуудал байгаа. 30 гаруй хуудас байгаа. Энд та бүхэнд 5 хуудсыг тараасан байгаа. 30-аад хуудас нь ямар юм бэ гэхлээр иргэдийн гарын үсэгтэй зүйл байгаа. Тэгэхээр Дэд хорооны гишүүд өнөөдөр өнгөрсөн долоо хоногт Даргын зөвлөл дээр энэ хурал маань саяын сэдвээр зарлагдсан байсан учраас сэдэв нэмж болохгүй байсан учраас одоо Улсын Их Хурлын гишүүд, Хүний эрхийн дэд хорооны гишүүд энэ нөхцөл байдалтай танилцчихаасай гэж хүсэж байна. Энэ дээр бид нар бас Дэд хорооныхоо гишүүдтэй ярилцаж үзээд Мөнхбаясгалан гишүүнд Мөнхбаясгалан гишүүн ээ эргээд танд хариу өгье за юу.

Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн дэд хорооны хурал үүгээр өндөрлөж байна.

11.24 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР